



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Дэрэн сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/5/НА-СТА-ТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Мандалговь хот  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох  
Утас: 70592439  
Цахим хаяг: [Munkhtogtokhr@audit.gov.mn](mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Наранцацрал  
Утас: 70592225  
Цахим хаяг: [Narantsatsralkh@audit.gov.mn](mailto:Narantsatsralkh@audit.gov.mn)

Ахлах аудитор: Т.Батсайхан  
Утас: 70593113  
Цахим хаяг: [batsaikhant@audit.gov.mn](mailto:batsaikhant@audit.gov.mn)

Аудитор: Т.Оюун-Эрдэнэ  
Утас: 70593113  
Цахим хаяг: [Oyunerdenet@audit.gov.mn](mailto:Oyunerdenet@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.4 Материаллаг байдал.....	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	13
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
4.1 Албан шаардлага.....	14
4.3 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	15

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХШҮДАХ	Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЭМТ	Эрүүл мэндийн төв



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

᠒᠐᠒᠒.᠐3.᠒5. № 88.

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭРЭН  
СУМЫН ЗАСАГ ДАРГА  
ЛАМАРТҮВШИН ТАНАА**

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Дэрэн сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Дэрэн сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

0012020912

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

**Дундговь аймгийн Дэрэн сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

			сарын 31	сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		770,310.2	1,155,899.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	217,805.9	503,726.2
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	196,078.7	230,874.9
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	355,975.6	410,847.9
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	450.0	10,450.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		5,527,008.5	5,649,897.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	5,527,008.5	5,649,897.5
39200	Биет хөрөнгө		5,460,866.6	5,583,954.6
39300	Биет бус хөрөнгө	13	66,141.9	65,942.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		6,297,318.6	6,805,796.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		3,949.0	28,257.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	3,949.0	28,257.2
41300	Өглөг	17а, 17б	3,949.0	28,257.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		6,293,369.6	6,777,539.4
51	Засгийн газрын хувь оролцоо		6,293,369.6	6,777,539.4
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		1,673,411.6	1,673,411.6
51200	Хуримтлагдсан үр дүн		3,333,306.8	3,817,476.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,286,651.2	1,286,651.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		6,297,318.6	6,805,796.6

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		5,177,827.4	3,127,731.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО		89,531.9	263,188.9
110	Орлогын албан татвар		31,519.0	31,265.8
1100	Хувь хүний орлогын албан татвар		31,519.0	31,265.8
113	Хөрөнгийн албан татвар		390.0	55,445.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж		57,623.0	176,477.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	2,614,125.4	693,721.4
120	Нийтлэг татварын бус орлого		2,614,125.4	693,591.4
121	Хөрөнгийн орлого		0.0	130.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,474,170.0	2,170,820.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,680,773.3	2,638,826.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,680,773.3	2,638,826.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,966,826.4	2,537,499.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,116,734.6	1,171,307.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		138,357.1	150,157.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		183,292.3	202,099.8
2104	Хангамж, бараа материалын зардал		75,742.0	120,314.5
2105	Нормативт зардал		74,976.7	229,614.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		15,135.5	15,655.8
2107	Томилолт, зочны зардал		9,740.5	5,632.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		42,847.2	20,366.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		310,000.6	622,351.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		713,946.8	101,326.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		2,497,054.1	488,905.2
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0.0	0.0

**Дундговь аймгийн Дэрэн сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		58,972.0	4,735.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		2,438,082.1	484,169.7

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,852,617.5	0.0	3,852,617.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,670.0	0.0	2,670.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,855,287.5	0.0	3,855,287.5
9	Тайлант үеийн үр дүн	2,438,082.1	0.0	2,438,082.1
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,293,369.6	0.0	6,293,369.6
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,293,369.6	0.0	6,293,369.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,293,369.6	0.0	6,293,369.6
19	Тайлант үеийн үр дүн	484,169.7	0.0	484,169.7
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,777,539.4	0.0	6,777,539.4

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,658,325.0	2,455,674.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	89,531.9	263,188.9
110	Орлогын албан татвар	31,519.0	31,265.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	31,519.0	31,265.8
113	Хөрөнгийн албан татвар	390.0	55,445.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	57,623.0	176,477.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,455.8	7,922.9
1181	Газрын төлбөр	1,117.2	2,290.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	52,050.0	166,264.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	94,623.0	124,382.0
120	Нийтлэг татварын бус орлого	94,623.0	124,252.0
121	Хөрөнгийн орлого	0.0	130.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,474,170.0	2,068,103.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,427,539.6	2,010,602.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,427,539.6	2,010,602.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,713,329.9	1,903,266.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,116,734.6	1,152,226.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	138,357.1	150,157.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	183,292.3	202,884.8
2104	Хангамж, бараа материалын зардал	71,939.6	113,513.9
2105	Нормативт зардал	62,444.2	132,065.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,648.0	14,722.1
2107	Томилолт, зочны зардал	9,740.5	5,632.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,861.5	23,065.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,312.1	108,998.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	714,209.7	107,336.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	230,785.4	445,071.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	151,063.6	159,151.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	151,063.6	159,151.5
2200	Догоод эх үүсвэрээр	151,063.6	159,151.5
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0

Дундговь аймгийн Дэрэн сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-151,063.6	-159,151.5
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-87,000.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	87,000.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-7,278.2	285,920.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	225,084.1	217,805.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	217,805.9	503,726.2

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,211,588.3	1,917,767.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,946,898.9	1,833,777.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,888,927.9	1,776,031.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,135,090.5	1,125,860.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	148,189.5	146,486.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	200,262.7	199,782.7
2104	Хангамж, бараа материалын зардал	64,526.0	63,022.2
2105	Нормативт зардал	76,566.1	61,852.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	82,843.6	82,227.2
2107	Томилолт, зочны зардал	6,328.0	5,632.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,976.5	13,412.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	161,145.0	77,756.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,971.0	57,745.2
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,971.0	57,745.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	162,692.7	83,990.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	101,996.7	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,211,588.3	2,068,732.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,225,074.2	1,224,145.6
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	748,008.0	741,280.3
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20,907.8	9,622.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	217,598.3	93,683.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	144,196.3
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	295,161.7
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	601.00	599.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6.00	6.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	105.00	104.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	385.00	385.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	306.00	306.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	79.00	79.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		259,145.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ		259,145.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		210,482.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		26,366.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		3,671.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		3,102.17
2104	Хангамж, бараа материалын зардал		50,779.74
2105	Нормативт зардал		70,212.61
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		4,368.45
2107	Томилолт, зочны зардал		-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,		12,652.86

**Дундговь аймгийн Дэрэн сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

	хураамж		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		39,328.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		48,662.67
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		-
2132	Бусад урсгал шилжүүлэг		26,600.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		22,062.67
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		263,639.60
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		263,639.60
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		4,494.46
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4,494.46

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Дэрэн сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Т.Оюун-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг дарга 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Дундговь аймгийн Дэрэн сум нь эрхэм зорилгоо “Уламжлалт ёс заншил, өв соёлоо эрхэмлэн дээдэлж, мал аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээ эрчимтэй хөгжсөн, эдийн засгийн чадавхтай, хүний хөгжлийг хангасан, оюунлаг, бүтээлч иргэдтэй, байгаль орчинд ээлтэй хөгжингүй сум байхад оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас төсөвт байгууллагуудын 2021 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, төсөв захирагч нарт дотоод аудитын тайланг хүргүүлсэн байна. Мөн аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар дотоод хяналтыг гүйцэтгэсэн, аймгийн Засаг даргын Тамгын газрын ХШҮДАХ-ээс төсөвт байгууллагууд болон сумын үйл ажиллагаанд жил бүр хяналт, шалгалт, үнэлгээг хийж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Дэрэн сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,638,826.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 26,388.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 18,471.8 мянган төгрөгөөр тогтоосон.

### 3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.5.1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дундговь аймгийн Дэрэн сумын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 508,478.0 мянган төгрөгөөр буюу 8.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцооны данс байна.

Хүснэгт 1

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1.0	2.0	3=2-1

**Дундговь аймгийн Дэрэн сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Мөнгөн хөрөнгө	217,805.9	503,726.2	285,920.3
Авлага	196,078.7	230,874.9	34,796.2
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	356,425.6	421,297.9	64,872.3
Үндсэн хөрөнгө	5,527,008.5	5,649,897.5	122,889.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>6,297,318.6</b>	<b>6,805,796.6</b>	<b>508,478.0</b>
Өр төлбөр	3,949.0	28,257.2	24,308.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,293,369.6	6,777,539.4	484,169.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>6,297,318.6</b>	<b>6,805,796.6</b>	<b>508,478.0</b>

Тайлант онд мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 503,726.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 285,920.3 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 5,649,897.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 122,889.1 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 285,920.3 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлогод төлөвлөгөө батлагдаагүй орлогууд орж, орлогын төлөвлөгөө нэр төрөл бүрээр давж биелсэн, сум хөгжүүлэх сангаас тус онд төсөл сонгон шалгаруулаагүй, зээл олгоогүйтэй тус тус холбоотой байна.

Үйл ажиллагааны орлого 3,127,731.1 мянган төгрөг буюу өмнөх оноос 2,050,096.3 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардал 2,638,826.0 мянган төгрөг буюу өмнөх оноос 41,947.3 мянган төгрөгөөр тус тус буурсан байна. Үйл ажиллагааны орлогын бууралт нь өмнөх онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын байр хүлээн авч санхүүгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор тайлагнасангай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,777,539.4 мянган төгрөг болж өмнөх оноос 484,169.8 мянган төгрөгөөр өссөн нь нэгтгэлд хамрагдсан байгууллагуудын тайлант оны үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

**3.5.2 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт**

Дэрэн сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 3 дугаар тогтоолоор тайлант онд 96,545.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 293,847.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 3 дахин давуулан биелүүлсэн байна.

*Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого*

*/мянган төгрөг/*

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
<b>Татварын орлого</b>				
Үйл ажиллагааны орлого	20,000.0	28,405.8	8,405.8	142.0
Хадгаламжийн хийгийн орлого	19,395.0	28,302.4	8,907.4	145.9
Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого		2,860.0	2,860.0	
Бууны албан татвар	360.0	480.0	120.0	133.3
Улсын тэмдэгтийн хураамж	1,140.0	1,816.0	676.0	159.3
Хог хаягдлын үйлчилгээ	2,700.0	6,003.9	3,303.9	222.4
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	100.0	103.0	3.0	103.0
Байгалийн нөөц ашигласны төлбөр		166,264.0	166,264.0	#DIV/0!
Газрын төлбөр	750.0	2,290.9	1,540.9	305.5
Малын тоо толгойн албан татвар	50,000.0	54,965.3	4,965.3	109.9
<b>Дүн</b>	<b>94,445.0</b>	<b>291,491.3</b>	<b>197,046.3</b>	<b>308.6</b>
<b>Татварын бус</b>				
Хүү торгууль	2,100.0	2,226.0	126.0	106.0
Бусад орлого		130.0	130.0	
<b>Дүн</b>	<b>2,100.0</b>	<b>2,356.0</b>	<b>256.0</b>	<b>112.2</b>

Нийт дүн	96,545.0	293,847.3	53,981.5	152.8
----------	----------	-----------	----------	-------

*Эх сурвалж: Дэрэн сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үйл ажиллагааны орлого 8,405.8 мянган төгрөгөөр, хадгаламжийн хүүгийн орлого 8,907.4 мянган төгрөгөөр, агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж 166,264.0 мянган төгрөгөөр тус тус давсан нь материаллаг дүнтэй байна.

Үйл ажиллагааны орлого нь малчдын ноос, арьс ширний урамшуулал жилийн эцэст орсноос, агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж орлогын төлөвлөгөө батлагдаагүй боловч жилийн эцэст Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас эдлэг шонхор, ногтруу шувуу барих тусгай зөвшөөрөл олгосонтой холбоотойгоор давж биелсэн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Дэрэн сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 13 дугаар тогтоолоор сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,216,729.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,216,729.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, баталсан байна.

Дэрэн сумын ИТХ-ын 2021 оны 09 сарын 09-ны өдрийн 3 дугаар тогтоолоор батлагдсан төсөвт тодотгол хийж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг тус бүр 5,140.8 мянган төгрөгөөр бууруулан, 2,211,588.3 мянган төгрөгөөр баталсан байна. Санхүүжүүлэх эх үүсвэрт тусгай зориулалтын шилжүүлгийг нэмэгдүүлэн орон нутгийн төсвийг хасаж, урсгал зардлыг нэмэгдүүлэн хөрөнгийн зардлыг хасаж баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд сумын Засаг даргын хэрэгжүүлэх 14 хөтөлбөрт зориулан 2,211,588.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,946,898.9 мянган төгрөгийг урсгал зардалд, 162,692.7 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 101,996.7 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,225,074.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 748,008.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 20,907.8 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 217,598.3 мянган төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,224,145.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 741,280.3 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 9,622.9 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 93,683.7 мянган төгрөг, нийт 2,068,732.5 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 71,844.5 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 7,482.4 мянган төгрөгөөр, туслах үйл ажиллагааны орлого 21,839.2 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 7,989.2 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогод Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, туслах үйл ажиллагааны орлогод төсөвт байгууллагуудын Ахмадын сан болон Мал хамгаалах сангийн өвсний борлуулалтын орлогыг тайлагнадаг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,917,767.1 мянган төгрөг буюу 86.7 хувьтай байгаа нь урсгал зардал 113,121.8 мянган төгрөг, хөрөнгийн зардал 78,702.7 мянган төгрөг, эргэн төлөгдөх зээлийн гүйлгээ хийгдээгүйгээс 101,996.7 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 928.6 мянган төгрөгийг улсын төсөвт, 6,727.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 27,880.7 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 67,775.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 26,501.2 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас нэмэлт орлого 141,482.6 мянган төгрөг, нийт 263,639.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлстэй холбоотой зардалд 30,038.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 3,102.2 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 50,779.9 мянган төгрөг, нормативт зардал 70,212.6 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 4,368.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 12,652.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 39,328.6 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 48,662.7 мянган төгрөг, нийт 267,120.4 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 22,062.7 мянган төгрөгийг төвлөрүүлж, үлдэгдэл 4,494.5 мянган төгрөгийг харилцахын үлдэгдлээр тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 АСУУДЛЫГ ОНЦОЛСОН ХЭСЭГ БА БУСАД АСУУДЛЫН ХЭСЭГ

Тайлант онд санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын үйл ажиллагаанд дараах онцлох асуудлууд байна. Үүнд:

Ерөнхий боловсролын сургууль:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжсэн 32,890.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжсэн 10,000.0 мянган төгрөгийн гадна талбайн хашааг тус тус хүлээн авч, тайлагнасан байна;

Засаг даргын Тамгын газар:

1. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжсэн 29,800.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 10,000.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг тус тус хүлээн авч, тайлагнасан байна;
2. Байгалийн гамшигт үзэгдэлд нэрвэгдсэн малчдад туслах хандивын аяныг өрнүүлэн 27,880.7 мянган төгрөгийг төвлөрүүлснийг шатахууны талон болгон тараасан байна;

Эрүүл мэндийн төв:

1. Ковид-19 цар тахал тархсантай холбоотой эмийн зардал өмнөх оноос 4.9 дахин өссөн байна. Тайлант онд эм боох материалын дансанд хандив, тусламжаар 116,875.5 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 88,447.6 мянган төгрөг, нийт 205,323.2 мянган төгрөгөөр эм боох материалыг орлого авч, 192,397.2 мянган төгрөгийн материалыг зарцуулсан байна;

2. Ковид-19 халдварын цар тахалтай тэмцэх арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн яамнаас эм, эмийн хэрэгслүүдийг аймгийн Эрүүл мэндийн газраар дамжуулан хуваарилсан байна. Хуваарилсан эмийн нэг бүрийн үнийг оронгийн цэг, таслалын алдаанаас 10 дахин өсгөж илүү нэхэмжилсэн 90 ширхэг эмийн үнийн зөрүү 1,156.6 мянган төгрөгийн зөрүү, анхан шатны баримтыг ирүүлээгүй тул орлого аваагүй байсан 1,698.2 мянган төгрөгийн эмийг Эрүүл мэндийн газартай тооцоо нийлж, санхүүгийн тайланд тусган залруулга хийсэн байна.

### 3.8 АУДИТЫН ГОЛ АСУУДАЛ

Санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудаас санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй тул гол асуудал байгаагүй.

Харин төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэгдсэн тайланд аудитын гол асуудал нь сумын ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 3 дугаар тогтоолоор 2021 оны төсөвт тодотгол хийхдээ Эд хогшил, урсгал засварын зардал 10,969.0 мянган төгрөг байсныг тодотголоор 82,843.6 мянган төгрөг болгож 71,874.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан нь Засгийн газрын 2021 оны 2-р сарын 17-ны өдрийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43-р тогтоолын 1.1-т *үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлиггүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*/, 1.4 *энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх*/ заасныг тус тус зөрчсөн асуудал байна.

### 3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Дэрэн сум нь 2021 онд нийт 319,314.3 мянган төгрөгийн 165 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн, хугацаанд нь байршуулан мэдээлсэн.

### 3.9.2 БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХҮРЭЭНД

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол, Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 292 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Аж ахуйн харилцааны дүрэм” зөрчсөн зөрчлүүдийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт, зөрчил арилгах албан шаардлагыг тус тус хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

### 3.10 ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Дэрэн сумын төсөвт байгууллагуудад 2021 онд завсрын аудит хийгдээгүй байна.

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын төсвийн шууд захирагч нарт 577.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 21,085.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 14 албан шаардлага хүргүүлсэн ба бүрэн хэрэгжсэн байна.

*Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	2	577.9	2	577.9			100.0
Албан шаардлага	14	21,085.8	14	21,085.8			100.0
Зөвлөмж							100.0
<b>Нийт</b>	<b>16</b>	<b>21,663.7</b>	<b>16</b>	<b>21,663.7</b>			<b>100.0</b>

### 3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн байгууллагуудын шатахуун, хүнсний материал, Эрүүл мэндийн төвийн эмийн зарцуулалтад дараагийн завсрын аудитаар горим, сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

### 4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 7 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангуудад “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 204,521.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 181,878.5 мянган төгрөгийн 7 алдааг аудитын явцад залруулж, 686.0 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 21,862.9 мянган төгрөгийн 7 зөрчлийг арилгах албан шаардлага, 94.4 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 11.1 хувийг залруулагдаагүй, 88.9 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Сумын нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Орон нутгийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тусгай зориулалтын сангуудын тайланд хийсэн аудитаар нийт 84,521.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 12,647.1 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага, 71,874.6 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлээ.

Нийт алдаа зөрчлийг ангиллаар нь харуулбал нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 188,954.6 мянга, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 87,306.8 мянга, арвилан хэмнэлттэй холбоотой 135.0 мянга, дотоод хяналт, хариуцлагатай холбоотой 12,647.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил тус тус илэрсэн байгаа нь дотоод хяналтыг сайжруулан нягтлан бодогч нарын ур чадвар, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

#### **4.1 Албан шаардлага**

Аудитаар илэрсэн дараах зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх хугацаатай албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Байгаль хамгаалах сангийн санхүүгийн тайлан дахь 4,532.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
2. Мал хамгаалах сангийн санхүүгийн тайлан дахь 8,114.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;

#### **4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сумын ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 3 дугаар тогтоолоор 2021 оны төсөвт тодотгол хийхдээ Эд хогшил, урсгал засварын зардал 10,969.0 мянган төгрөг байсныг тодотголоор 82,843.6 мянган төгрөг болгож 71,874.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан нь Засгийн газрын 2021 оны 2-р сарын 17-ны өдрийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43-р тогтоолын 1.1-т /үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахгаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах/, 1.4 /энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх/ заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсөвт тодотгол хийхдээ холбогдох хууль, тогтоомжийг баримтлан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 7 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/ д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:</b>											
1	ЕБС	1	-					1	-		
2	Соёлын төв	1	3,290.0					1	3,290.0		
3	ЭМТ	1	-					1	-		
4	ЗДТГ	2	4,983.0					2	4,983.0		
5	ИТХ	2	5,589.9					2	5,589.9		
6	ТТЗ	1	71,874.6							1	71,874.6
	Дүн	8	85,737.5	0	-	0	-	7	13,862.9	1	71874.6
<b>2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:</b>											
1	Цэцэрлэг	1	94.4							1	94.4
2	ЭМТ	5	154,546.7	3	153,860.7	2	686.0				
3	ЗДТГ	3	27,093.9	3	27,093.9						
4	ИТХ	0	-								
5	ОНХС	1	8,000.0					1	8,000.0		
6	СХС	1	923.9	1	923.9						
7	ТЗС	2	12,647.1					2	12,647.1		
	Дүн	13	203,306.0	7	181,878.5	2	686.0	3	20,647.1	1	94.4
	<b>Нийт зөрчлийн дүн</b>	<b>21</b>	<b>289,043.5</b>	<b>7</b>	<b>181,878.5</b>	<b>2</b>	<b>686.0</b>	<b>10</b>	<b>34,510.0</b>	<b>2</b>	<b>71,969.0</b>